

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА  
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Жаргалант сумын 6 дугаар Сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ХОА-2022/71/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Ховд хот  
2022 он

Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар

Утас: 70433061

Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn

Аудитын менежер: А.Цэцэгсүрэн

Утас:70432545

Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn

Ахлах аудитор: Д.Нарантуул

Утас: 70432545

цахим хаяг: narantuuld@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	1
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	3
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	3
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	5
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	7
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	8
3. Аудитын тайлан .....	9
3.1 Ерөнхий зүйл .....	9
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	10
3.4 Материаллаг байдал .....	10
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....	11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	11
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	12
3.8 Аудитын гол асуудал .....	12
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	12
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	12
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	13
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	13
4. Аудитын илрүүлэлт.....	13
4.1 Залруулсан алдаа .....	13
4.2 Төлбөрийн акт.....	
4.3 Албан шаардлага .....	13
4.4 Зөвлөмж .....	Error! Bookmark not defined.
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	14

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч
НА	Нийцлийн аудит
БСУГ	Боловсрол соёл урлагийн газар
ХОНТСА	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан
ДЗОУБ	Дэлхийн зөн олон улсын байгууллага
ХХК	Хариуцлагатай хувьцаат компани
ЭМГ	Эрүүл мэндийн газар



**ХОВД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**  
Увс Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд  
Телефон: 976-70433061, Факс: 976-70433061  
E-mail: khovd@audit.gov.mn

46  
ЖАРГАЛАНТ СУМЫН 6 ДУГААР  
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ  
Б.БАРСБОЛД ТАНАА

2021.12.14 № 2/38  
-ны № -Т

**АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ**

**Эерчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн гүйцэтгэлийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Жаргалант сумын 6 дугаар сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр мөнгөний өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд гаргасан.

Жаргалант сумын 6 дугаар сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх үзүүлэлт зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу аудитыг шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж амжилсан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу мэдээлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу мэдээлэлээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт гаргах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэж баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл өөрөөр уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛДБААТАР

021030405

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Төгрөгөөр

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<u>162,806,053.21</u>	<u>176,538,660.58</u>
33	<b>АВЛАГА</b>	13,663.08	212,021.00
33,100	Ажиллагчидтай холбогдсон авлага	13,663.08	212,021.00
35	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	162,792,390.13	176,326,639.58
351	<b>Түүхий эд материал</b>	4,315,300.00	2,984,099.00
35,130	Эм боох материал	4,315,300.00	2,984,099.00
354	<b>Хангамжийн материал</b>	158,477,090.13	173,342,540.58
35,410	Бичиг хэргийн материал	2,032,250.00	2,032,250.00
35,420	Аж ахуйн материал	2,741,277.00	2,741,277.00
35,470	Бусад хангамжийн материал	153,703,563.13	168,569,013.58
2	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<u>2,039,477,779.46</u>	<u>1,960,331,452.26</u>
39	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	2,039,477,779.46	1,960,331,452.26
392	<b>Биет хөрөнгө</b>	1,733,474,279.38	1,654,442,202.14
39,201	Барилга, байгууламж, орон сууц	1,722,942,059.34	1,722,942,059.34
39,202	Хуримтлагдсан элэгдэл	(163,391,580.24)	(249,740,334.04)
39,205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	252,597,815.43	276,044,391.53
39,206	Хуримтлагдсан элэгдэл	(222,668,883.60)	(237,732,612.32)
39,207	Тавилга, аж ахуйн эд хогшил	164,703,226.73	168,876,726.73
39,208	Хуримтлагдсан элэгдэл	(91,711,238.49)	(103,616,067.77)
39,217	Ном	57,506,662.90	77,668,038.67
393	<b>Биет бус хөрөнгө</b>	306,003,500.08	305,889,250.12
39,301	Программ хангамж	857,000.00	857,000.00
39,302	Хуримтлагдсан элэгдэл	(628,499.92)	(742,749.88)
39,303	Бусад биет бус хөрөнгө	305,775,000.00	305,775,000.00
3	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<u>2,202,283,832.67</u>	<u>2,136,870,112.84</u>
4	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<u>41,860.82</u>	<u>53,937.82</u>
41	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	41,860.82	53,937.82
413	<b>Өглөг</b>	41,860.82	53,937.82
41,310	Ажилчидтай холбогдсон өглөг	41,860.82	53,937.82
5	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<u>2,202,241,971.82</u>	<u>2,136,816,175.02</u>
51	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	2,202,241,971.82	2,136,816,175.02
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,788,204,349.11	1,788,204,349.14
51,101	Өмч: - төрийн	305,775,000.00	305,775,000.00
512	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	(374,411,673.24)	(439,837,470.07)
51,210	Өмнөх үеийн үр дүн	(374,411,673.24)	(374,411,673.24)
51,220	Тайлант үеийн үр дүн	-	(65,425,796.83)
51,300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	788,449,295.95	788,449,295.95
6	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<u>2,202,283,832.64</u>	<u>2,136,870,112.84</u>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	2,103,080,435	1,934,541,191.65
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	118,330,758	54,353,838.32

120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	3,347,195	54,353,838.32
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	3,347,195	54,353,838.32
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	360,000	600,000
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	2,987,195	53,753,838.32
122	<b>Тусламжийн орлого</b>	114,983,563	-
122001	Хандив тусламж /дотоод/	114,983,563	-
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	1,984,749,677	1,880,187,353.33
1310	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	1,591,594,400	1,524,784,300
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,591,594,400	1,524,784,300
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	124,795,177	76,917,619
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	124,795,177	76,917,619
1320	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	268,360,100	278,485,434.33
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	268,360,100	278,485,434.33
2	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	1,947,662,159	1,986,470,771.17
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	1,947,662,159	1,986,470,771.17
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,873,981,356	1,882,770,407.59
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	1,343,551,431	1,298,582,224.10
210101	Үндсэн цалин	876,538,284	910,443,954.10
210102	Нэмэгдэл	354,232,706	305,635,762
210103	Унаа хоолны хөнгөлөлт	18,928,000	-
210104	Урамшуулал	93,852,441	82,502,508
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	167,829,404	168,507,994.90
210201	Тэтгэврийн даатгал	114,626,627	117,094,779.96
210202	Тэтгэмжийн даатгал	13,483,790	13,013,095.25
210203	ҮОМШӨ-ний даатгал	10,780,312	10,410,476.19
210204	Ажилгүйдлийн даатгал	2,625,798	2,544,513.04
210205	Эрүүл мэндийн даатгал	26,312,877	25,445,130.46
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	234,013,343	276,758,534.33
210301	Гэрэл, цахилгаан	4,058,352	3,692,180.20
210302	Түлш, халаалт	198,374,192	240,384,482.13
210303	Цэвэр, бохир ус	31,580,800	32,681,872
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	4,012,900	4,069,173.50
210401	Бичиг хэрэг	794,600	1,179,435
210402	Тээвэр, шатахуун	55,000	54,600
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,051,000	314,488.50
210404	Ном, хэвлэл	49,000	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	630,000	665,400
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,433,300	1,855,250
2105	<b>Нормативт зардал</b>	4,976,750	7,333,954
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	3,312,800	5,452,354
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,663,950	1,881,600
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	3,726,900	5,425,100
210604	Урсгал засвар	3,726,900	5,425,100
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	160,000	386,600
210702	Дотоод албан томилолт	160,000	386,600
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	767,000	4,817,000
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		3,809,000
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	767,000	1,008,000
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	114,943,627	116,889,826.76
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	326,300	571,850
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,674,550	2,886,415
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	110,942,777	113,431,561.76
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	73,680,804	103,700,363.58
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	29,247,200	102,283,584

213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	29,247,200	41,334,900
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	60,948,684
2133	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	44,433,604	1,416,779.58
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	44,433,604	1,416,779.58
3	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<u>155,418,275</u>	<u>(51,929,579.52)</u>
225	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	-	13,496,217.31
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	13,496,217.31
4	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	-	(13,496,217.31)
5	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<u>155,418,275</u>	<u>(65,425,796.83)</u>

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Төгрөгөөр

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	<b>2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	1,788,204,349	788,449,296	(529,829,949)	2,046,823,696
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	1,788,204,349	788,449,296	(529,829,949)	2,046,823,696
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	155,418,275	155,418,275
C08	<b>2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	1,788,204,349	788,449,296	(374,411,673)	2,202,241,972
D01	<b>2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	1,788,204,349	788,449,296	(374,411,673)	2,202,241,972
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	1,788,204,349	788,449,296	(374,411,673)	2,202,241,972
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(65,425,797)	(65,425,797)
D09	<b>2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	1,788,204,349	788,449,296	(439,837,470)	2,136,816,175

### 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<u>1,862,246,318</u>	<u>1,880,900,707</u>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	1,931,818	600,000
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	1,931,818	600,000
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	1,931,818	600,000
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,931,818	600,000
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	1,860,314,500	1,880,300,707
1310	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	1,591,594,400	1,524,784,300
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,591,594,400	1,524,784,300
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	360,000	76,917,619
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	360,000	76,917,619

1320	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	268,360,100	278,485,434
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	268,360,100	278,485,434
1340	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	-	113,354
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	-	113,354
2	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<u>1,862,246,318</u>	<u>1,880,900,707</u>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	1,862,246,318	1,880,900,707
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,789,365,514	1,777,086,990
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	1,345,847,295	1,280,395,911
210101	Үндсэн цалин	845,731,300	800,235,912
210102	Нэмэгдэл	383,481,489	410,545,199
210103	Унаа хоолны хөнгөлөлт	19,622,295	-
210104	Урамшуулал	97,012,211	69,614,800
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	165,285,358	186,880,589
210201	Тэтгэврийн даатгал	115,526,400	131,984,104
210202	Тэтгэмжийн даатгал	12,439,000	13,623,971
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,951,200	12,831,914
210204	Ажилгүйдлийн даатгал	2,487,800	2,585,500
210205	Эрүүл мэндийн даатгал	24,880,958	25,855,100
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	248,929,343	276,758,534
210301	Гэрэл, цахилгаан	4,058,352	6,633,000
210302	Түлш, халаалт	213,290,192	231,717,734
210303	Цэвэр, бохир ус	31,580,800	38,407,800
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	4,953,400	7,192,778
210401	Бичиг хэрэг	857,600	1,625,900
210402	Тээвэр, шатахуун	200,000	172,600
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,281,900	1,281,900
210404	Ном, хэвлэл	807,000	586,800
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	438,600	2,158,000
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,368,300	1,367,578
2105	<b>Нормативт зардал</b>	9,915,050	2,587,500
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	7,451,100	705,900
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,463,950	1,881,600
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	3,726,900	4,626,800
210604	Урсгал засвар	3,726,900	4,626,800
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	160,000	446,600
210702	Дотоод албан томилолт	160,000	446,600
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	767,000	11,608,000
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		10,600,000
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	767,000	1,008,000
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	9,781,168	6,590,278
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	600,000	600,000
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9,181,168	5,990,278
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	72,880,804	103,813,718
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	28,447,200	102,396,938

213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	-	113,354
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	28,447,200	41,334,900
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	60,948,684
2133	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	44,433,604	1,416,780
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	44,433,604	1,416,780

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

төгрөгөөр

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	1,860,554,500	1,816,120,896	1,793,718,800	1,792,302,020
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	1,860,554,500	1,816,120,896	1,793,718,800	1,792,302,020
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,817,549,800	1,787,673,696	1,750,975,700	1,750,967,120
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	1,343,424,200	1,345,847,295	1,292,754,600	1,280,395,911
210101	Үндсэн цалин	845,731,300	845,731,300	855,789,700	800,235,912
210102	Нэмэгдэл	391,691,900	383,481,489	367,350,100	410,545,199
210103	Унаа хоолны хөнгөлөлт	17,199,200	19,622,295		
210104	Урамшуулал	88,801,800	97,012,211	69,614,800	69,614,800
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	181,362,200	165,285,358	174,521,900	186,880,589
210201	Тэтгэврийн даатгал	127,625,300	115,526,400	122,811,700	131,984,104
210202	Тэтгэмжийн даатгал	13,434,300	12,439,000	12,927,500	13,623,971
210203	ҮОМШӨ-ний даатгал	10,747,400	9,951,200	10,342,100	12,831,914
210204	Ажилгүйдлийн даатгал	2,686,800	2,487,800	2,585,500	2,585,500
210205	Эрүүл мэндийн даатгал	26,868,400	24,880,958	25,855,100	25,855,100
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	264,633,200	248,929,343	266,607,600	266,607,600
210301	Гэрэл, цахилгаан	6,633,000	4,058,352	6,633,000	6,633,000
210302	Түлш, халаалт	226,419,400	213,290,192	221,566,800	221,566,800
210303	Цэвэр, бохир ус	31,580,800	31,580,800	38,407,800	38,407,800
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	4,972,900	4,953,400	4,725,300	4,723,843
210401	Бичиг хэрэг	877,100	857,600	877,100	876,365
210402	Тээвэр, шатахуун	200,000	200,000	172,600	172,600
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,281,900	1,281,900	1,281,900	1,281,900
210404	Ном, хэвлэл	807,000	807,000	586,800	586,800
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	438,600	438,600	438,600	438,600
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,368,300	1,368,300	1,368,300	1,367,578
2105	<b>Нормативт зардал</b>	9,952,700	9,915,050	2,587,500	2,587,500
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	7,451,100	7,451,100	705,900	705,900
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,501,600	2,463,950	1,881,600	1,881,600
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	3,726,900	3,726,900	1,726,900	1,726,800
210604	Урсгал засвар	3,726,900	3,726,900	1,726,900	1,726,800
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	614,000	160,000	446,600	446,600
210702	Дотоод албан томилолт	614,000	160,000	446,600	446,600
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	767,000	767,000	1,008,000	1,008,000
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	767,000	767,000	1,008,000	1,008,000

2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	8,096,700	8,089,350	6,597,300	6,590,278
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	600,000	600,000	600,000	600,000
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,496,700	7,489,350	5,997,300	5,990,278
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	43,004,700	28,447,200	42,743,100	41,334,900
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	43,004,700	28,447,200	42,743,100	41,334,900
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	43,004,700	28,447,200	42,743,100	41,334,900
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	1,860,554,500	1,816,120,896	1,793,718,800	1,792,302,020
1310	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	1,591,594,400	1,547,160,796	1,524,784,300	1,523,367,520
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,591,594,400	1,547,160,796	1,524,784,300	1,523,367,520
1320	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	268,360,100	268,360,100	268,334,500	268,334,500
132001	Орон нутгийн төсвөөс	268,360,100	268,360,100	268,334,500	268,334,500
120004	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	600,000	600,000	600,000	600,000
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	600,000	600,000	600,000	600,000
61	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	1	1	1	1
610001	Төсвийн байгууллага	1	1	1	1
62	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	97	97	97	97
620001	Удирдах ажилтан	1	1	1	1
620002	Гүйцэтгэх ажилтан	72	72	72	72
620003	Үйлчлэх ажилтан	24	24	24	24
65	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	97	97	97	97
650004	СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	73	73	73	73
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	24	24	24	24

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	24,557,564	87,181,907
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	24,557,564	87,181,907
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	9,670,670	26,119,869
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	6,900,110	-
210102	Нэмэгдэл	6,900,110	
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	-	10,150,934
210302	Түлш, халаалт		10,150,934
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	-	2,468,935
210401	Бичиг хэрэг		749,535
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		1,719,400
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	-	2,900,000
210604	Урсгал засвар		2,900,000
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	-	10,600,000
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		10,600,000
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	2,770,560	-
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	170,560	
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,600,000	

213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	14,886,894	61,062,038
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	14,886,894	61,062,038
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	14,886,894	113,354
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг		60,948,684
II	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	24,557,564	76,917,619
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	24,557,564	76,917,619
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	23,657,564	76,917,619
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	900,000	

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Жаргалант сумын 6 дугаар сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, төсвийн зарцуулалт, анхан шатны баримтын бүрдүүлэлттэй холбоотой зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг ахлах аудитор Д.Нарантуул 2022 оны 02 дугаар сарын 12-ноос 2021 оны 02 дугаар сарын 15-ний хооронд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер А.Цэцэгсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Болдбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Тус байгууллага нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 8 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Жаргалант сумын 6 дугаар Сургууль нь “Хүүхдийн өөрийн удирдлагатай суралцахуйг дэмжин, багш-сурагч-эцэг эхийн хамтын оролцоог хангаж, хосолсон сургалтын үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулан сурлагын хоцрогдлыг арилгах” гэсэн зорилтыг дэвшүүлжээ. Үүнд:

- Хүүхдийн онцлог, ялгаатай хэрэгцээнд тулгуурлан амжилттай суралцах, хөгжлийг дэмжихэд чиглэсэн төсөлт ажил, арга хэмжээг нутгийн захиргааны байгууллага, эцэг эх, асран хамгаалагч, олон нийтийн оролцоотой зохион байгуулах, хамтын ажиллагаа түншлэлийг идэвхжүүлэх,
- Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлийн үед хичээл, сургалтыг тасралтгүй үргэлжлүүлэх бэлэн байдлыг хангаж, цахим хичээлийн сан болон идэвхтэй суралцах, суралцагчийн бие даан ажиллах үйлийг дэмжсэн дасгал, даалгаврын сан бүрдүүлж үр дүнтэй ашиглах,
- Хүүхэд бүрийн онцлог, ялгаатай хэрэгцээнд тулгуурлан сурах, хөгжих үйлийг дэмжиж хичээл, сургалтын үйл ажиллагаанд тэдний оролцоог тэгш хангаж, хамтран суралцах соёлыг төлөвшүүлэх,

- *Ахлах ангийн суралцагч ажил мэргэжлийн чиг баримжаатай болох, мэргэжлээ зөв сонгоход дэмжлэг үзүүлэхэд чиглэсэн зорилтот арга хэмжээг төлөвлөн үр дүнтэй ажиллах,*
- *Элсэлтийн ерөнхий шалгалтын хэмжээст оноо, чанарын үнэлгээний судалгаа болон бусад хөндлөнгийн шалгалтын дүн оноог өмнөх жилүүдийнхээс ахиулах,*
- *Дижитал технологийг хичээл, сургалтын үйл ажиллагааны үндсэн хэрэгсэл болгон хөгжүүлэх, түүнийг үр дүнтэй ашиглахад багш нарын мэргэжлийн бүлгийн үйл ажиллагааг чиглүүлж багш ажлын байрандаа тасралтгүй хөгжих боломжийг бүрдүүлэх,*
- *Хичээл сургалтын өдөр тутмын үйл ажиллагааг асуудалд бүтээлчээр хандах, шийдлийн эрэл хайгуул хийх, учир шалтгааныг илрүүлэх, шийдвэрлэх, үнэлгээ, дүгнэлт хийх үйлд чиглүүлэх,*
- *"Чадварлаг багш, сурагч", "Чанартай боловсрол", "Монгол хэл, бичиг", "Тогтвортой хөгжлийн боловсрол" дэд хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж, үр дүнг тооцох,*
- *Бусад байгууллагатай хамтын ажиллагааны сүлжээ үүсгэн харилцан туршлага солилцох, багшийн болон сургалтын орчны нөөцөд тулгуурлан хичээл, сургалтын үйл ажиллагааг хамтран зохион байгуулах замаар үйлчилгээний чанар, үр ашгийг сайжруулах,*

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- *Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолоор "төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай"*
- *Засгийн газрын 2021 оны 237 тоот тогтоолоор "Үдийн хоолны норматив тогтоох тухай"*

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх санхүүгийн хяналт дотоод аудитын албанаас тус байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналт хэрэгжүүлээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Жаргалант сумын 6 дугаар Сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### **3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогоор сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл "Дунд" гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2021 оны жилийн эцсийн орлого үр дүнгийн тайлангийн нийт орлогын 459.8 сая төгрөгөөс 1.5 хувиар тооцон 6.9 сая төгрөгөөр материаллаг байдлыг тооцон, санхүүгийн тайлангийн түвшинд гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 5.2 сая төгрөгөөр тогтоолоо.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга**

Жаргалант сумын 6 дугаар Сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 65.4 сая төгрөгөөр буюу 3 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, өглөг, үндсэн хөрөнгийн данс байна.

Тайлант оны эхэнд болон эцэст мөнгөн хөрөнгийн үлдэгдэлгүй байна

Бараа материалын дансны үлдэгдэл 191.1 сая төгрөг болж 28.3 сая төгрөгөөр өссөн нь аймгийн Онцгой комисс, ЭМГазар, Жайка төсөл, ДЗОУБ-аас эм, боох материал, Мон судар ХХК, Аз жур ХХК-аас бусад хангамжийн материалыг үнэ төлбөргүйгээр хүлээн авсантай холбоотой нэмэгдсэн байна.

Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 20.9 сая төгрөгийн бараа материал бэлтгэж, үнэ төлбөргүйгээр 12.4 сая төгрөгөөр нийт 33.3 сая төгрөгөөр нэмэгдэж, 19.8 сая төгрөгийн материалыг зарцуулжээ.

Авлагын данс оны эцэст 0.01 сая төгрөгийн үлдэгдэлтэй, өмнөх оноос 0.2 сая төгрөгөөр өссөн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл оны эхэнд 2,517.8 сая төгрөг байсан бол оны эцэст 2,552.1 сая төгрөг болж 47.8 сая төгрөгөөр өссөн нь тайлант онд төсөл хөтөлбөрийн санхүүжилтээр хөрөнгө худалдан авсантай холбоотой нэмэгдсэн байна.

Тайлант онд 6.4 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэж, үнэ төлбөргүйгээр 41.3 сая төгрөгийн хөрөнгө хүлээн авсан, 13.5 сая төгрөгийн ном сурах бичгийг акталж устган тайлант оны эцэст 1,960.3 сая төгрөгийн цэвэр үндсэн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

Тайлант оны эцэст 0.05 сая төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн өр төлбөр үүссэн байна.

Засгийн газрын оролцоо дансны оны эхний үлдэгдэл 2,202.2 сая төгрөг байсан оны эцэст 2,136.8 сая төгрөг болж тайлант онд 65.4 сая төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан бичилт хийгдээгүй ба тайлант оны хуримтлагдсан үр дүнгийн эцсийн үлдэгдэл 440.2 сая төгрөг болсон байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Жаргалант сумын 6 дугаар сургууль нь 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,808.2 сая төгрөгөөр, нийт зарлагыг 1,808.2 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Ховд аймгийн ТЕЗ-аас тус байгууллагын төсвийг 1,793.7 сая төгрөгөөр батлан ирүүлжээ.

### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд 1,793.7 сая төгрөгийн төсөв баталснаас 1,524.8 сая төгрөгийг улсын төсвөөс, 268.3 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, туслах үйл ажиллагааны орлогоос 0.6 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,524.8 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 268.3 сая төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоос 0.6 сая төгрөг нийт 1,793.7 сая төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 1,792.3 сая төгрөгийг зарцуулж 1.4 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,792.3 сая төгрөг буюу 99.9 хувьтай байгаа нь төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшууллын зардлыг 1.4 сая төгрөгөөр хэмнэсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт тайлангийн тайлангаар аймгийн БСУГ-аас ариутгалын зардалд 0.8 сая, өвөлжилтийн бэлтгэл хангахад 1.0 сая, ХОНТСА-ны тэтгэмжид 3.6 сая бүгд 5.4 сая төгрөгийн санхүүжилт авч зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

АДБОУС 701.8-д тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

### **3.8 Аудитын гол асуудал**

АДБОУС 701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хяналаа.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллээс 147 хугацаандаа оруулсан 4 мэдээлэл хугацаа болоогүй, холбогдох мэдээллийг хугацаанд нь мэдээлсэн ч дараа жилийн төсвийн төсөл, хагас жилийн санхүүгийн тайлан, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш дүн бүхий орлого буюу сар бүрийн санхүүжилтийн орлогын 37, зарлагын 11 ажил гүйлгээ болон дараа жилийн төсвийн төсөл, батлагдсан төсөв, хагас жилийн санхүүгийн тайлан баланс зэрэг мэдээллийг мэдээлээгүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай бүрэн нийцээгүй байна гэж дүгнэлээ.

#### **Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 36.3 сая төгрөгийн 3.5 сая төгрөгийн залруулга, 32.8 сая төгрөгийн 3 зөвлөмж өгөгдөж хэрэгжүүлэн ажилласан байна.

#### **3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Дараагийн аудитаар аймгийн БСУГ-аас Ковид-19 цар тахалтай холбоотой ариутгалын бодис худалдан авах 1.2 сая төгрөгийн санхүүжилт олгож, ариутгалын бодис худалдан авахдаа зах зээлийн үнэ ханш худалдан авсан талаар асуудлыг авч үзэх зүйтэй байна.

### **4. Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 24.2 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 16.1 төгрөгийн алдааг залруулж, 8.1 сая төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өглөө.

#### **4.1 Залруулсан алдаа:**

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Санхүүгийн байдлын тайлан, үндсэн хөрөнгийн тодруулгад 13.6 сая төгрөгийн акталсан хөрөнгийн дансны кодыг буруу сонгон хөрөнгийн үлдэгдлээр хасах тэмдэгтэй тусгасан,
2. Төсвийн гүйцэтгэлийн тайланд татан төвлөрүүлсэн мөнгөөр тохируулах бичилт хийгээгүй 1.4 сая төгрөг,
3. Аймгийн ЭМГ-аас Ковид-19 цар тахалтай холбоотой үнэ төлбөргүй олгосон эм эмнэлгийн хэрэгслийг орлогоор хүлээн зөвшөөрч бүртгээгүй,
4. Тайлант үеийн үр дүнг 0.6 сая төгрөгөөр зөрүүтэй,

**Шийдвэрлэсэн нь:** Байгууллагын удирдлага, нягтлан бодогч нарт асуудлын бүртгэлээр танилцуулан 16.1 сая төгрөгийн залруулга хийж, залруулсан 2022 оны 02 дүгээр сарын 17-ны 15 тоот албан бичгээр санхүүгийн тайланд залруулга хийсэн болно.

#### **4.2 Зөвлөмж:**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

##### **4.3.1 Шилэн данстай холбоотой асуудал**

**Илрүүлэлт:** Шилэн дансны хуульд заасан сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн хэмнэлт, хэтрэлтийн шалтгаан тайлбарыг бичээгүй, дараа жилийн төсвийн төсөл, хагас жилийн санхүүгийн тайлан болон 5 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй орлого, зарлагын гүйлгээг цахим сайтад мэдээлээгүй байгаа нь *Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.6-д “төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбарыг улирал бүр”, 6.4.5-д “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр;” Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан журмыг зөрчсөн байна.*

**Өгсөн зөвлөмж:** Хууль, журамд заасны дагуу холбогдох мэдээллийг үнэн мэдээлж хэвших

##### **4.3.2 Төсвийн зарцуулалттай холбоотой асуудал**

**Илрүүлэлт:** Засгийн газрын 43 дугаар тогтоолын дагуу батлагдсан төсөвт зардлын 10-аас доошгүй хувийн хэмнээгүй, ажлын байрны тодорхойлолтод тусгаагүй 1.4 сая

төгрөгийн мэргэшлийн зэрэг дэв олгосон, хамтын гэрээний заалт нь холбогдох хууль, журмын заалтыг үндэслэн нэмэгдэл цалин олгосон нь *Засгийн газрын 2021 оны 2 дугаар сарын 17-ны 43 дугаар тогтоолын 1.1-д "үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах", Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.3-д "төрийн жинхэнэ албан хаагчд цол, зэрэг дэвийн нэмэгдлийг давхардуулан олгохгүй"* гэсэн заалтуудыг мөрдөөгүй зөрчил илэрлээ.

**Өгсөн зөвлөмж:** Дотоод журмын заалтуудыг холбогдох хууль журмын заалтыг үндэслэн тусган өөрчлөх, нэмэгдлийг давхардуулан олгохгүй байх

#### 4.3.3 Анхан шатны баримтын бүрдүүлэлттэй холбоотой

**Илрүүлэлт:** Бэлтгэн нийлүүлэгч байгууллагад 10 дугаар сарын 25-аас 11 дүгээр сарын 11 хүртэл хугацааны ирцийн бүртгэлгүй, нотлох баримтгүй 6.7 сая төгрөгийг үдийн хоолны зардалд, нэмэлт санхүүжилтийн данснаас төсөл хөтөлбөрийн сургалтын төлбөрийг шилжүүлэхдээ сургалтын төлөвлөгөө, хамрагдсан багш болон бусад холбогдох анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлээгүй ажил гүйлгээ гаргасан нь *Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7-д "анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно"* гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлэн ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 05 дүгээр сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

### 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая. төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Жаргалант сумын 6 дугаар сургууль	7	24.2	4	16.1	-	-	-	-	3	8.1

### ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР